



Монгол Улсын  
Засгийн газар



Люксембургийн  
Засгийн газар



Mongolia

“Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн  
тогтолцоог боловсронгуй болгох нь” МОН/08/305 төсөл

# ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН АЮУЛД БЭЛЭН БАЙЦГААЯ

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА №1

Улаанбаатар хот  
2011 он

## “ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН АЮУЛД БЭЛЭН БАЙЦГААЯ”

### Иргэдэд зориулсан гарын авлага

**Бэлтгэсэн:** МОН/08/305 төслийн ажилтан П.Байгалмаа

**Редактор:** ОБЕГ-ын ахлах мэргэжилтэн, дээд ахмад М.Сүхбаатар

© “Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” МОН/08/305 төслөөс 2000 ширхэг хэвлүүлэв.

**Хаяг:** Сүхбаатар дүүрэг, Партизаны гудамж – 6  
Онцгой Байдлын Ерөнхий Газар, 302, 303 тоот өрөө  
ШХ-46/1009, Улаанбаатар хот, Монгол Улс  
Утас: 976-11-315595, 976-11-328027  
Цахим шуудан: [secretary@mongoliadisaster.org](mailto:secretary@mongoliadisaster.org)

## АГУУЛГА

1. Газар хөдлөлтийн тухай ойлголт
2. Газар хөдлөлт болоогүй, тайван цагт авах арга хэмжээ
3. Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээ
4. Газар хөдлөлтийн дараа авах арга хэмжээ

### Хавсралт

1. Газар хөдлөлтийн үеийн бэлэн байдлын картын загвар
2. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, аврах, гал унтраах ангиудын хаяг байршил, утасны дугаар

Ашигласан материалын жагсаалт

## I. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ


### ГАЗАР ХӨДЛӨЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Газар хөдлөлтийг олон янзаар тодорхойлдог. Судалгааны талаас нь тодорхойлбол, “Дэлхийн цардсын мандалд тектоник хөдөлгөөнөөр хуримтлагдсан хүчдэл чөлөөлөгдөхөд ялгарах энергийн нэгээхэн хэсэг нь уян харимхайн долгион болон тархаж, газрын гадаргууд үйлчлэл үзүүлэх процессийг хэлнэ”.

Харин газрын гадаргууд үйлчилсэн байдлаар нь “Газрын гадаргууд олон зуун км урт хагарал үүсч, гол мөрөн голдирлоо, уул нурууд дүр төрхөө өөрчлөх, хот суурин, барилга байгууламж нуран, хүний амь нас олноор эрсдэх байгалийн гамшигт үзэгдлийг газар хөдлөлт гэнэ”. [Одон орон, геофизик судалгааны төв, 2007]

Газар хөдлөлт нь жилийн аль ч улиралд, өдөр шөнө ялгаагүй гэнэт тохиолдож болох хамгийн хор уршиг ихтэй байгалийн гамшигт үзэгдлийн нэг юм. Газар хөдлөлтийн улмаас байшин барилга агшин зуур эвдрэн сүйрч, олон хүний амь нас, эрүүл мэнд хохирдог. Газар хөдлөлт бүхэл бүтэн хот суурин газрыг сүйрүүлж, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой үйл ажиллагааг удаан хугацааны турш алдагдуулдаг.

**Учир шалтгаан.** Дэлхийн цардас нь далай тэнгисийн доор 10 км, эх газрын доор 65 км хүртэл гүн үргэлжилсэн чулуулаг давхаргаас тогтдог. Цардсын бүтэц нь нэг цул биш бөгөөд хэдэн зуун мянган км үргэлжилсэн хэд хэдэн томоохон хавтангуудаас тогтдог. Тектоник хавтангийн онолоор хавтангууд нь илүү хөдөлгөөнтэй хучаасууд дээр байрлах бөгөөд байнгын хөдөлгөөнд байдаг. Хавтангууд нь харилцан шүргэлцэхэд ачаалал үүсч, заадсаар шилжих бөгөөд эдгээрийг хавтангуудын дагуух төрлөөр



Зураг 1.

1. Хэвийн байдал
2. Тектоник хөдөлгөөний үр дүнд хагарлын дагуу хүчдэл хуримтлагдана
3. Хүчдэл чөлөөлөгдөж, уян харимхайн долгион тархана
4. Газар хөдөлсний дараа хавтангууд шилжсэн байдал

нь хэд хэд ангилна. Үүнд: а/ холдож хуваагдах буюу тасрах, б/ гулсах буюу шүргэлцэх, харилцан мөргөлдөх. Эдгээр бүх шилжилт нь газар хөдлөлтийг дагуулдаг.

Хавтангийн өөр хоорондоо харилцан шүргэлцэж, мөргөлдөж байгаа зааг хэсгийг хагарал гэж нэрлэдэг. Харилцан холбоосын уян харимхайн онолоор дэлхийн цардас нь хөдөлгөөнд байгаа тектоник хавтангуудын байнгын шахалтан дор оршдог учир хугацааны тодорхой хэсэгт тэр нь аюултай ачааллыг авна. Энэ тохиолдолд хагарлын дагуу ан цав үүсч, чулуулаг сууриуд өөрийн уян харимхайн хүчээр ачааллыг сулартал хөдөлнө. Ихэвчлэн хөдөлгөөн нь хагарлын хоёр талаас эсрэг чиглэлд явагддаг.

*Монгол орны нутаг дэвсгэрийн 70-аад хувь, төв суурин газрын 80 гаруй хувь нь газар хөдлөлийн 7 баллаас дээш бүсэд хамрагддаг. Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Булган, Баянхонгор аймгуудын ихэнхи сумд газар хөдлөлийн хүчтэй бүсэд багтдаг бөгөөд Улаанбаатар хот 6-8, Эрдэнэт 7-8, Дархан 9 баллын бүсэд оршдог.*

Газар хөдлөлтөөр үүссэн энерги нь хүчтэй эвдрэл сүйрлийг байнга дагуулдаггүй, зарим тохиолдолд тэр нь их бус хэмжээгээр аажим ялгардаг. Газар хөдлөлтөнд өртөмхий орнуудад бүр бага хэмжээний энергийн ялгарал ба газрын цардас дахь шилжилтүүд өдөр бүр бүртгэгдэж байдаг боловч эдгээр шилжилтүүд нь хотыг газартай тэгшилж чадахуйц харьцангуй цөөн тохиолддог том хэмжээний газар хөдлөлтийг үүсгэж болох нь батлагдаагүй. Зарим газар хөдлөлт галт уулын үйл ажиллагаатай холбоотой байдаг боловч ихэнхи хамгийн хор уршиг ихтэй газар хөдлөлтүүд газрын цардасны гэнэтийн хагаралтай холбоотой байх шиг ажиглагддаг. Газар хөдлөлт өөр өөр байдаг нь голомтоос ялгарч байгаа энергийн хэмжээ, голомт хүртэлх зай, гүний хэмжээ болон гадаргын чулуулгын болон хөрсний бүтэцтэй холбоотой байдаг.

*Дэлхий дээр жилд 500 мянга орчим газар хөдлөлт болдгийн зөвхөн 100 орчим мянга нь л хүмүүст мэдрэгддэг байна. [Wikipedia]*

**Ерөнхий шинж чанар.** Газар хөдлөлтийн чичирхийлэл нь янз бүрийн хүч, давтамжтай байдаг. Хүчтэй газар хөдлөлтийн үед яг хагарах явц нь хэдхэн секундээс нэг минут хүртэл хугацаанд үргэлжилдэг. Хагарлаас үүссэн сейсмик долгион нь хэдэн секундээс хэдэн минут үргэлжилж болно.

Гадаргуугийн долгионууд нь хөрсийг хэвтээ болон босоо чиглэлд чичрүүлдэг. Эдгээр долгионууд нь газар хөдлөлтийн голомтоос их хол байсан ч өндөр барилгыг ганхуулж, усны мандалд долгион үүсгэдэг.

Газар хөдлөлтийн голомтын гүн нь долгионы шинж чанар болон учруулах хор уршгийг тодорхойлоход чухал хүчин зүйл болдог.

**Газар хөдлөлтийн тогтоц.** Дэлхийн тодорхой хэсгүүд газар хөдлөлтөнд маш эмзэг байдаг. Ихэнх газар хөдлөлтүүд Номхон далайн бүс гэж нэрлэгддэг Номхон далайтай хиллэдэг газруудад, мөн Зүүн Энэтхэг, Гималайн нуруу, Иран, Турк болон Балканы хойгийг хөндлөн гарсан Альпийн бүсэд их тохиолддог байна. Газар хөдлөлт Алетутийн арал, Тонга, Япон, Чили, Зүүн Карибын тэнгис гэх мэт далай тэнгисийн сав газар олонтаа тохиолддог. Ойролцоогоор газар хөдлөлтийн 95% нь хавтангуудийн заагууд дээр болдог байна.

Ази тив нь газар хөдлөлтийн аюулын өндөр зэрэгтэйд тооцогддог эх газар юм. Монголын газар хөдлөлийн идэвхжилд нөлөөлөх гол хүчин зүйл нь Энэтхэгийн хавтан Ази тивийг 50 орчим сая жилийн өмнө мөргөсөн ба одоо хүртэл жилд 5 см (ЖПС-ийн тусламжтайгаар тогтоогдсон) хурдтайгаар хойш шахаж байгаа явдал юм. Мөн нөгөө талаас байгалийн рифтийн таталцал Монгол орны газар хөдлөлд нөлөөлөх бас нэгэн хүчин зүйл болж байна.

### Газар хөдлөлтийн эх үүсвэрүүд

Тектоник газар хөдлөлт - Хавтангийн хөдөлгөөнөөр хуримтлагдсан хүчдэл чөлөөлөгдөхөд үүснэ. Тектоник газар хөдлөлт нь ихэнх тохиолдолд хэдэн арван болон хэдэн мянган жилийн өмнө хүчтэй газар хөдлөлтийн улмаас үүссэн газрын хагарлуудын орчинд болдог.

Газрын гүнд үүссэн агуй болон гүний уурхайн үйл ажиллагаанаас үлдсэн хоосон хөндий нүхний нуралтаар үүсэх газар хөдлөлт. Тус үзэгдлээс үүсэх хэмжээний газар хөдлөлт нь хүчний хувьд харьцангуй сулхан болдог.

Галт уулын газар хөдлөлт идэвхитэй галт уулын дэлбэрэлтээр үүснэ. Энэ газар хөдлөлт нь бага талбайг хамарч доргилт мэдрэгдэнэ.

Уул уурхайн болон цөмийн тэсэлгээгээр үүсэх газар хөдлөлт - Зарим цөмийн тэсэлгээ нь дунд зэргийн хүчтэй газар хөдлөлттэй тэнцэхүйц үйлчлэлийг үзүүлнэ.

**Балл ба магнитудын ялгаа.** Газар хөдлөлтийн хэлбэлзлийн хүчийг XII баллын шаталбараар ажиглалтын цэг бүрт тодорхойлдог бол магнитуд (M) нь газар хөдлөлтийг бүртгэх багажинд тэмдэглэгдсэн газар хөдлөлтийн голомтын хүч бөгөөд тоон хэмжигдэхүүн юм. Балл нь тус бүс нутгийн хувьд зай болон геологийн нөхцлөөс хамааран янз бүрийн утгатай байдаг бол

Магнитуд нь тухайн газар хөдлөлтийн хувьд зөвхөн нэг л утга агуулсан байдаг. Одоогоор дэлхийн 4 төрлийн баллын шаталбарыг хэрэглэж байгаа бөгөөд эдгээрээс Япон улсад бусдаас ялгаатай буюу 9 баллын шаталбарыг ашигладаг.

### Балл ба Рихтерийн шаталбарын шүтэлцээ [Одон орон, геофизик судалгааны төв, 2007]

БАЛЛ	РИХТЕРИЙН ШАТАЛБАР
I. Хөрсний хэлбэлзэл зөвхөн багажинд мэдрэгдэнэ.	2.5 Хүнд мэдрэгдэхгүй, зөвхөн багажинд мэдрэгдэнэ.
II. Тайван орчинд хүмүүс чичиргээг мэдрэнэ.	
III. Цөөн тооны хүмүүс чичиргээг мэдрэнэ.	3.5 Мэдэгдэм сул газар хөдлөлт
IV. Газар хөдлөлт олон хүмүүст мэдрэгдэнэ. Шил цонх даржигнана.	
V. Өлгөөстэй зүйлс ганхаж, унтагсад сэрнэ.	
VI. Барилга, байгууламжинд хөнгөн гэмтэл учирч, өнгөн шавардлагад нарийн цав үүснэ.	4.5 Мэдэгдэм хүчтэй газар хөдлөлт
VII. Барилга, байгууламжийн өнгөн шавардлагад цав гарч зарим хэсэг ховхрон унаж, хананд ан цав үүснэ.	
VIII. Хананд томоохон ан цав гарч, төвийлгөсөн хөвөө, утааны яндан унана.	6.0 Хүчтэй газар хөдлөлт
IX. Зарим барилгууд нурна. Хана, хучилт дээвэр нурна.	
X. Олон барилга нурна. Хөрс шороонд 1 м хүртэл ан цавууд үүснэ.	7.0 Томоохон хүчтэй газар хөдлөлт
XI. Ууланд нуралт болж, газрын гадаргууд олон тооны ан цавууд үүснэ.	8.0 ба түүнээс дээш Сүйрэлт газар хөдлөлт
XII. Гадарга зүйд томоохон хэмжээний өөрчлөлт орно.	

**Газар хөдлөлтийн аюул.** Газар хөдлөлттэй холбоотой гол аюулууд нь хагарлуудын шилжилт болон гадаргуугийн эвдрэл, ан цав юм. Хоёр дахь аюулуудад хөрсний эвдрэл, хөрс усжих, хөрсний гулсалт, цасны нуранги, цунами болон усны түвшингийн хэлбэлзэл орно.

Хөрсний эвдрэл – Газар хөдлөлийн чичирхийлэлт нь байшин барилгын доорхи бэхжиж нягтаршсан хөрсөнд суулт үүсгэдэг. Лаг шавар, элсэрхэг хөрсүүд нь газар хөдлөлтийн үед илүүтэй эвдрэх магадлалтай байдаг.

Хөрс усжих – Чийг авч дэвтсэн хөрс бат бэх хатуулаг чанараа алдах нь хөрсний эвдрэлийн нэг хэлбэр юм. 1964 онд Японы Ниигатад болсон газар хөдлөлтийн үед байшин барилгын доорхи газар хөдлөлтөнд тэсвэртэй байсан хөрс усжсанаас байшин барилга хажуулдан унасан. Газар хөдлөлтөөс үүсэх хөрсний эвдрэлийн өөр нэг төрөл бол хөрсний суулт буюу хөрсөн дэхь усны даралт буурснаас үүсэх эгц доошоо чиглэсэн газрын хөдөлгөөн юм.

Хөрсний гулсалт ба цасны нуранги – Газрын тогтворгүй налуу байдлаас газар хөдлөлтийн үед хөрсний гулсалт болон цасны нуранги үүсдэг. Налуу ихтэй байх, сул хөрс, ус зэрэг нь эмзэг байдалд нөлөөлдөг. Хэвгий газрын хөрс чийгтэж сулрах нь аюултай гулсалт болоход нөлөөлнө. Газар хөдлөлтөөс үүдэлтэй хөрсний гулсалтын хамгийн элбэг тохиолддог төрлүүд бол хад чулууны нуранги, налуу ихтэй газраас үүссэн хад чулууны гулсалт юм.

Цунами ба усны түвшингийн хэлбэлзэл – Эдгээр нь далай тэнгисийн доорхи эсвэл эргийн ойролцоох газар хөдлөлтөөс үүсч, далайн эргээр маш их хүчтэй сүйрэл учруулдаг. Усны түвшингийн хэлбэлзэл (далайн булан тохой орчмын долгион)-ээс үүдэж үер болж, далан нуран, хөрсөнд болон усны түвшинд өөрчлөлт ордог байна.

*[2004 онд болсон Энэтхэгийн далайн цунамид Индонез, Шри-Ланка, Энэтхэг, Тайланд зэрэг 14 орны 230 орчим мянган хүний амь нас алдсан бөгөөд дэлхийн түүхэн дэхь хамгийн их хохирол сүйрлийг авчирсан байгалийн гамшиг болсон юм. Далайн гүнд болсон 9,1-9,3 магнитудын газар хөдлөлтийн нөлөөгөөр 30 м хүртэлх асар том хэмжээний далайн давалгаа нөмрөн ирж, эдийн засгийн болон байгаль орчны асар их хохирол учруулжээ. Wikipedia]*



Монголын газар нутаг дахь газар хөдлөл нь Алтай, Говь-Алтай, Хангай, Хөвсгөл, Булнайн нуруу орчмоор олонтаа тохиолддог байна. Томоохон хэмжээний газар хөдлөлийн эпицентр нь 9-10 баллаас давдаг. Монголд 6 баллаас дээш хүчтэй газар хөдлөлт сүүлийн 20-иод жилд 40 гаруй удаа болжээ. XX зуунд 8 баллаас дээш хүчтэй газар хөдлөлт 4 удаа тохиолдож байсан зэргээс үзэхэд Монгол орон бүхэлдээ газар хөдлөлийн аюултай бүсэд оршиж байна. [Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга зүй, 2010]

### Улаанбаатар хотод мэдрэгдсэн газар хөдлөлтүүд:

- 2005 оны 12-р сарын 3-нд Улаанбаатарын цагаар 08.50.06 цагт Төв аймгийн Лүн сумын Зүрх ууланд магнитуд нь 5 хүчтэй газар хөдлөлт болсон нь Улаанбаатар хотын Налайх дүүрэг хотын зарим хэсгээр, Их тэнгэрийн ам зэрэг газарт;
- 2006 оны 2-р сарын 18-нд Улаанбаатарын цагаар 09.52 цагт Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумаас хойш 17 км-т Бүтээлийн нуруунд магнитуд нь 5.2 хүчтэй газар хөдлөлт болж Орхон, Булган аймагт, Улаанбаатар хотын 40 мянгат, I, X хороолол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн нутаг дэвсгэрт;
- 2006 оны 4 сарын 30-нд Улаанбаатарын цагаар 09.45 цагт Өвөрхангай аймгийн Арц богдод Рихтерийн шаталбараар 5.9 магнитудын хүчдэлтэй газар хөдлөлт болж, чичирхийлэлт нь Баянхонгор, Дундговь, Өмнөговь аймаг, Улаанбаатар хотын I, XI, VI бичил хороолол болон Чингэлтэй, Улиастай орчмын нутгаар;
- 2006 оны 6 дугаар сарын 15-нд Говь-Алтай аймгийн Гичгэний нуруунд магнитуд нь 6 хүчтэй газар хөдлөлт болж, нийслэлийн зарим дүүргийн нутагт;
- 2008 оны 8-р сарын 27-нд 09.35.28.01 цагт Улаанбаатар хотоос 463 км-т магнитуд нь 6.1 хүчтэй газар хөдлөлт Байгаль нуурын орчим болж, хотын ихэнх дүүрэгт 2-3 баллаар;
- 2010 оны 1-р сарын 9-ний өдрийн 15.06 цагт Дундговь аймгийн Дэлгэрцогт сумаас хойд зүгт 11 км зайд магнитуд нь 5.6 хүчтэй газар хөдлөлт болж, Улаанбаатар хотын Баянгол, Сонгино-Хайрхан дүүргийн нутаг дэвсгэрт 5 орчим баллаар тус тус мэдрэгджээ.
- Мөн сүүлийн жилүүдэд нийслэл хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн идэвхитэй голомт Сонгино, Сонсголонгийн хөндий, Сонгинын амралт орчимд мэдрэгдэх болж, 2007 онд 423 удаагийн чичирхийлэлт мэдрэгдсэн байна.

Улаанбаатар хотыг газрын хөрсний хэв шинжээр нь авч үзвэл Туул голын сэвсгэр хурдас газар хөдлөлийн өндөр эрсдэлтэй газарт тооцогддог. Өндөр нарийвчлалтай сансрын зураг, хээрийн ажлын судалгаагаар Улаанбаатар хотын орчмын 200 км газарт хэд хэдэн шулуун ан цав тогтоогдсон нь болзошгүй газар хөдлөлтийн голомтууд болж болзошгүй, магнитуд нь 7.5 хүртэлх газар хөдлөлт болох магадлал бүхий бүс нутаг гэж эрдэмтэд, судлаачид тодорхойлсон байна. [Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга зүй, 2010]

### Урьдчилан мэдэх боломж

**Уламжлалт аргууд.** Түүхийн явцад газар хөдлөл судлаачдын ажиглан тогтоосон нэлээд хэдэн шинж тэмдэг байдаг. Үүнд: 1.Барилга байшин зөөлхөн чичирдэг. 2.Ан амьтан, шувууд цочирдсон байдалтай болдог. 3.Худгийн усанд өөрчлөлт орж, ус нь булингартай, муухай үнэртэй болдог. Эдгээр шинж тэмдгүүд нь дэлхийн өнцөг булан бүрд газар хөдлөлтөөс амьд үлдэгсдийн дурсамжаар баталгааждаг.

**Шинжлэх ухааны аргууд болон багаж, тоног төхөөрөмжүүд.** Хэдийгээр зарим эрдэмтэд газар хөдлөлтийг урьдчилан мэдэх боломжтой гэдэг боловч урьдчилан мэдэх аргууд нь одоог хүртэл маргаантай байдаг. Худгийн ус нэмэгдэх, булингартай болох, худгийн усанд нэвчиж байгаа радон хийний бичлэг зэрэг шинжлэх ухаанд харшлахгүй аргуудаар урьдчилан тааварлаж болох ч ан амьтдын байдалд гарч байгаа өөрчлөлтийг газар хөдлөх гэж байгаагаас болж байна гэж тайлбарлах нь нотлогдоогүй тул ашиглахад маргаантай асуудал юм.

#### ЦУНАМИ гэж юу вэ?

Хүчтэй газар хөдлөлтийн улмаас далай тэнгисийн ус их хэмжээгээр өргөгдөж, том хэмжээний давалгаа үүсгэх үзэгдэл. Цунами нь усны түвшнээс хамааран цагт 600-800 км/цаг хурдалдаг. Гэхдээ 7,5 болон түүнээс дээш магнитудын газар хөдлөлт л цунамиг үүсгэдэг гэж үзэж байна. [Wikipedia]

### Эмзэг байдалд нөлөөлдөг хүчин зүйлүүд

Хүн амын эмзэг байдлыг нэмэгдүүлдэг зарим гол хүчин зүйлүүдэд:

- Хот, суурин газар өргөжин тэлэхийн хэрээр суурьшмал хүн амын тоо нэмэгдэж байгаа;
- Газар хөдлөлийн бүсэд, ялангуяа суларсан хөрсөн дээр, хөрсний гулсалтанд өртөмтгий газар эсвэл хагарлын шугамын дагуух орон сууцны барилгууд, суурьшилт;

- Газрын гадаргуугийн хэлбэлзэлд тэсвэргүй байшин барилга, гүүр, далан зэрэг байгууламжууд. Хүнд дээвэртэй тоосгон байшингууд нь хөнгөн модон хийцийн барилгаас илүү эмзэг байдаг.
- Газар хөдлөлтийн эрсдэл болон, авах анхан шатны арга хэмжээний талаарх ард иргэдийн мэдлэг, мэдээлэл хомс байх зэргийг оруулж болно.

### Газар хөдлөлтийн гамшгийн улмаас үүсэх хохирол, үр дагавар

Хүн, нийгмийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд:

- Олон хүний амь нас эрсдэж, хүнд хөнгөн гэмтэл, бэртэл гарна
- Олон хүн, айл өрх орох оронгүй болно
- Амьд үлдсэн хүмүүс өнчрөл хагацал үзэж, сэтгэл зүйн хямралд орно
- Төрийн байгууллагуудын хяналт алдагдаж болзошгүй
- Аврал тусламж эрсэн эмх замбараагүй байдал үүснэ
- Засаг захиргааны байгууллага болон ард иргэд мэдээллийн хомсдолд орох буюу худал мэдээлэл, цуу ярианд төөрөлдөж болзошгүй



Дэд бүтцийн салбартай холбоотой асуудлууд:

- Барилга байгууламж эвдэрч, нурна
- Гал түймэр гарна
- Гэрэл, дулаан тасрах буюу хязгаарлагдмал болно
- Усан хангамжийн сүлжээнд эвдрэл гэмтэл гарна
- Зам, гарц нурангид хаагдаж, тээврийн хэрэгслийн түгжрэл үүснэ
- Химийн хорт/аюултай бодис алдагдаж болзошгүй

- Харилцаа холбооны сүлжээнд гэмтэл гарч саатна
- Радио, телевизийн нэвтрүүлэг тасалдана
- Давтан хөдлөлт нь нэгэнт суларсан ба хагас нурсан барилга байгууламжуудад маш их хохирол учруулдаг.

Шөнийн цагаар газар хөдлөхөд унтаж байгаа хүмүүс түүний урьдчилсан чичиргээг мэдрэхгүйгээс гадна гамшгийн зарлан мэдээллийг авч чадахгүй учраас амь үрэгдэгсэд, шархдагсад ихтэй байдаг. [Өвлийн шөнө Улаанбаатар болон томоохон хот, суурин газарт хүчтэй газар хөдлөлт болвол ихээхэн хохирол эрсдэл дагуулна гэж НҮБ-ын гамшгийн судалгааны баг дүгнэжээ. 2005]

Өдрийн цагаар, ялангуяа сургууль, албан газар зэрэг өндөр, найдваргүй барилга байгууламжид байгаа хүмүүс их эрсдэлтэй байдаг. Тэнд байгаа хүмүүст их хохирол учирч болно. Газар хөдлөлтийг томоохон хөрсний гулсалт болон цунами зэрэг хоёрдогч аюул дагалдвал амь насаа алдагсдын тоо эрс өснө. Байшин барилга нь хөнгөн жинтэй бүтээц ялангуяа модон хийцтэй байгаа тохиолдолд амь үрэгдэгсэд, шархдагсдын тоо ерөнхийдөө харьцангуй бага байдаг боловч гал түймэр гарвал нэрвэгдэгсдийн тоог нэмэгдүүлдэг талтай.

**Эрүүл мэндийн асуудал.** Газар хөдлөлтийн үед эмнэлгийн тусламжийг хамгийн өргөнөөр шаардсан асуудал бол бэртэл, гэмтэл, хугарал байдаг.

Хэрвээ, газар хөдлөлтийг дагалдан үер болсон бол, усан хангамж тасалдаж, хүмүүс бохир ус хэрэглэсэн бол, түр байрнуудад хүмүүс их хэмжээгээр бөөгнөрсөн бол эрүүл мэндийн бусад асуудлуудыг үүсгэдэг.

Газар хөдлөлтөөс үүдэн цэвэр усны болон хүнсний хангамжинд доголдол гарах магадлалтай.

Бэлэн байдлын арга хэмжээнүүдээс олон нийтийн мэдлэг, мэдээллийг сайжруулах чиглэлийн асуудлууд ихээхэн анхаарал татах болсон. Энэ тухай дараагийн бүлгээс үзнэ үү.

*Веньчуань, Сичуань муж, БНХАУ, 69,195 хүн амь үрэгдэж, 18,392 хүн сураггүй алга болж, 374,643 хүн гэмтэж бэртсэн, 4,8 сая хүн орон гэргүй болсон.*

*Леогень, Порт-О-Принц хот, Гаити, 3 сая орчим хүн нэрвэгдсэнээс 316,0 мянган хүн нас барж, 300,0 мянган хүн гэмтэх буюу шархдаж, 1,0 сая орчим хүн орон гэргүй болжээ.*



## II. ГАЗАР ХӨДЛӨЛТ БОЛООГҮЙ, ТАЙВАН ЦАГТ АВАХ АРГА ХЭМЖЭЭ

### 2.1 Газар хөдлөлтийн аюулгүй байдлыг хангах 7 алхам

- Амьдарч байгаа орчныхоо аюулгүй байдлыг хангах;
- Газар хөдлөлтийн үед/дараах арга хэмжээний төлөвлөгөө гаргах;
- Өрхийн/хувийн бэлтгэлээ хангах;
- Байгууллага, иргэн бүр барилга байгууламжийг барих норм, норматив, стандартыг хатуу мөрдөж байх;
- Газар хөдлөлтийн үед яахаа/ямар үйлдэл хийхээ мэддэг байх;
- Газар хөдлөлтийн дараа биеийн гэмтэл, хохирлыг шалгах;
- Бэлэн байдлыг хангах дадлага, сургууль хийх;

#### Амьдарч байгаа орчныхоо аюулгүй байдлыг хангах

- o Байшин/барилгын бүх өрөөнүүдийг шалгаж, газар хөдлөлтийн үед эвдэрч гэмтэн, аюул учруулж болзошгүй тавилга, эд зүйлийг илрүүлж, засах, бэхлэх нь болзошгүй эрсдэлийг бууруулна.
- o Шатанд бариул хийх, мөн хальтардаггүй материал наах;
- o Шилэн хаалганы ойролцоо тавилга тавихгүй байх;



#### Зочны/унтлагын өрөөнд:

- o Хувцасны шүүгээ зэрэг овор хэмжээ ихтэй тавилга болон чичирхийлэх үед унаж эвдэрч болзошгүй эд зүйлсийг хананд бэхлэж, аюулгүй байдлыг хангах;
- o Зурагтыг өндөрт байрлуулахгүй байх;
- o Чемодан, хайрцагтай эд зүйлс зэрэг дээрээс унаж, гэмтэл учруулж

- болзошгүй хүнд эд зүйлсийг хувцасны шүүгээн дээр байрлуулахгүй байх;
- o Толь, зурагт зэрэг хүнд эд зүйлсийг ор, сандал, буйдан зэргээс аль болох хол тавих, тавиурын доод хэсэгт байрлуулах;
- o Тавиур дээрх ном болон бусад сул задгай эд зүйлс чичирхийллийн үед унаж, гэмтэл учруулж болзошгүй тул бэхлэх;
- o Унтлагын өрөө болон настайчууд, хүүхдүүдийн өрөөнд өндөр тавилга байрлуулахгүй байх;

#### Галын өрөөнд:

- o Хөргөгч болон галын өрөөний бусад тавилгуудын буланг ханатай бэхлэх;
- o Цахилгаан хэрэгслийг суурьтай нь бэхлэх, гэхдээ бэхэлгээний материал нь уян хатан сунадаг зүйл байхыг анхаарах;
- o Сав суулга, шилэн эдлэл унаж ирэхээс хамгаалж, галын өрөөний тавилгуудын хаалгыг сайн хаагддаг болгох;

#### Гараж болон агуулахад:

- o Шатаж, дэлбэрч болзошгүй материалыг гараж, агуулахад хадгалахаас зайлсхийх, зайлшгүй хадгалах тохиолдолд аюулгүй байдлыг хангах;
- o Эдгээр нь алдагдсан тохиолдолд машин болон бусад эд зүйлд хүрэхгүй байх;
- o Газар хөдлөлтийн үед гараж, агуулахад байхаас зайлсхийх;



#### Галын аюулаас урьдчилан сэргийлэх:

- o Утаа мэдрэгч гэртээ суурилуулж, ажиллагаатай эсэхийг тогтмол шалгах;
- o Газар хөдлөлтийн үед гарч болзошгүй гал түймрийн аюулаас сэрэмжлэх, хөшгөө шатамхай бус материалаар хийх;
- o Усны хувин зэрэг гал унтраах наад захын багаж хэрэгсэлтэй болох, түүнийгээ хэрэглэхэд бэлэн гарын доор байлгах;

- Цахилгаанаас үүдэлтэй гал гарсан тохиолдолд ус хэрэглэхгүй байхыг анхаарах;
- Гал унтраагуурыг хэрэглэж сурах;
- Хийн зуухны дээр шүүгээ байрлуулахгүй байх;

### Гал гарсан үед яах вэ?

- Бусдад яаралтай мэдэгдэх;
- 101 дугаарт утсаар дуудлага өг. Галыг асч эхэлж байх үед нь хяналтандаа авахыг хичээ. Хөршүүддээ мэдэгд;
- Яаралтай унтраах: гал гарсан үеийн эхний 3 минут маш чухал байдаг бөгөөд энэ хугацаанд ямар ч галыг унтраах боломжтой. Айж сандрахгүйгээр тайван байж, эхний шатанд нь галыг хяналтандаа авахыг хичээх хэрэгтэй.
- Галыг шалнаас дээш гараагүй байгаа/ эхний шатанд нь хяналтандаа байлгах боломжтой. Галын дөл хөшиг, таазанд хүрвэл хянахад хэцүү болно.
- Хэрэв ус юмуу, гал унтраагуур гарын дор бэлэн байгаа бол гал унтраах боломжтой.



### Газар хөдлөлтийн үед/дараах арга хэмжээний төлөвлөгөө гаргах

- Гэр бүлийн гишүүн бүр төлөвлөгөө боловсруулахад оролцох;
- Тогтмол дасгал сургууль хийх /хэвт, нуугд, хүлээ – дасгалыг олон удаа давтах/;
- Өрөө бүрийн аюулгүй газрыг олж тогтоох;
- Өрхийн гишүүн бүр нэг нэгэндээ дохио өгөх шүгэл буюу бусдад дохиог сонсгож сурах;
- Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх арга ажиллагаанд суралцах;



- Утсан холбоо тасарсан үед гэр бүлийнхэнтэйгээ хэрхэн холбоо барихаа урьдчилан тохиролцож, уулзах газраа мэдсэн байх;
- Хөршүүд болон СӨХ-ийн хүрээнд хамтын төлөвлөгөө гаргаж, хэн нь ямар чадвартай, хэн нь юуг анхаарч, бусаддаа ямар хэлбэрээр тусламж хүргэж болохыг ярилцаж тохиролцох;

### Өрхийн/хувийн бэлтгэлийг хангах

1. Хувцас. Хөлд эвтэйхэн спорт загварын гутал, оймсыг бэлтгэж ойр байлгах, хоолойтой цамц, хүрэм, 1-2 ээлжийн дотуур хувцас, оймс, алчуур саван, даавуун болон зузаан бээлий, хөнжил/аяны хөнжил
2. Гэр бүлийн гишүүдэд 3 хоногт хүрэлцэх хүнс. Цэвэр ус бэлтгэх, лаазалсан хүнс болон онгойлгогч, хуурай хүнс, халуун усанд уусгаж/дэвтээж идэх боломжтой хүнс
3. Анхны тусламжийн иж бүрдэлд орох зүйлс. Ариутгах, халдваргүйтгэх бодис/спирт, иод/, тосон түрхлэг, хөвөн даавуу, боолт, самбай, шархны наалт, хайч, гэр бүлийн гишүүдийн өдөр тутамдаа хэрэглэдэг эм
4. Бусад зүйлс. мөнгө, баримт бичиг, гар чийдэн, зай, жижиг хийн зуух, лаа, шүдэнз, асаагуур, радио, 1 боодол хөвөн даавуу, ус нэвтэрдэггүй/хулдаас, хутга, шүгэл, тэмдэглэлийн дэвтэр, харандаа
5. Өндөр настнуудад: дамнуурга, живх, эм тариа, шаардлагатай бусад асаргааны зүйл
6. Нялх хүүхдэд: хуурай сүү, угж, живх




### III. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

#### 3.1 Газар хөдлөлтийн үед биелүүлэх 10 дүрэм

1 дэхь дүрэм. Өөрийгөө болон гэр бүлээ хамгаал. Хүчтэй чичиргээ ихдээ л 1 минут үргэлжилдэг тул бат бөх ширээн доор орж, толгой дээрээ юм унаж ирэхээс хамгаалах хэрэгтэй. Хэрэв ширээ байхгүй бол овор ихтэй том тавилга болон цонхноос аль болох хол зайтай ханан талд очиж суух нь зүйтэй.



2 дахь дүрэм. Цахилгаан хэрэгслүүдийг салга. Галаас урьдчилан сэргийлэх нь дараачийн болзошгүй аюулаас хамгаална. Хийн болон цахилгаан зуухыг салгаж аюулгүй болгосон эсэхээ шалгах хэрэгтэй. Энэ нь багахан хэмжээний чичирхийллийн үед ч хамаарна. Гал гарсан тохиолдолд нэн даруй унтраа.



3 дахь дүрэм. Гадагш гарах гэж яарах хэрэггүй. Газар хөдлөлтийн үед гадагш, гудамжинд гарах нь аюултай. Орчин тойрныг ажиглаж, тайван байсан нь илүү дээр.



4 дэхь дүрэм. Хаалгаа нээлттэй орхих нь гадагш гарахад тустай. Цементэн ханатай орчин үеийн барилгуудын хувьд энэ нь зөв арга юм.



5 дахь дүрэм. Толгойгоо хамгаал. Хэрэв гадаа явж байхад чинь газар хөдлөвөл байшингийн мод, тоосго, цонхны шил, зарлалын самбар зэрэг гэмтээж болзошгүй зүйлсээс өөрийгөө хамгаалж хоргодох газар олох буюу нээлттэй, задгай талбай олохыг хичээгээрэй.



6 дахь дүрэм. Тухайн байгууллагын ажилтнуудын зөвлөгөөг дагаарай. Дэлгүүр, театр гэх мэт олон хүнтэй орчинд газар хөдлөвөл хүмүүс сандралд орох нь элбэг байдаг. Тайван байж, сандарч тэвдэхгүйгээр байгууллагын ажилтнуудын зөвлөгөө, зааварчилгааг дагаарай.



7 дахь дүрэм. Машинаа замын зүүн талд зогсоогоод, аюултай газраар жолоо барих хэрэггүй. Өөрөө мэдэж шийдвэр гаргах нь яахаа мэдэхгүй байдалд оруулж мэднэ. Радиогоор өгсөн мэдээллийн дагуу хөдлөх нь зүйтэй.



8 дахь дүрэм. Үер усны аюулаас болгоомжил. Хэрэв гол, устай газрын ойролцоо байдаг бол нэн яаралтай нүүх, өндөрлөг газарт очих хэрэгтэй.



9 дэхь дүрэм. Аль болох бага эд зүйл авч, явганаар нүүх. Машинаар явах нь замын түгжрэлд орохоос гадна гал унтраах болон аврах ажиллагаа зэрэгт саад болж болзошгүй юм.



10 дахь дүрэм. Бодит мэдээллийг ашиглах. Гамшгийн үед хүмүүс цуу ярианд автах, төөрөлдөх явдал их байдаг. Орон нутгийн удирдлага, цагдаагийн байгууллага болон Онцгой байдлын газраас өгч буй мэдээлэлд анхаарлаа хандуулах нь зүйтэй.



**3.2 Газар хөдлөлтийн үед та хаана байхаас шалгаалан дараах зөвлөмжүүдийг дагаарай:**

**Хэрвээ таныг ГЭРТЭЭ БАЙХ ҮЕД газар хөдлөвөл:**



1. Ширээн доогуур ор, боломжгүй бол дэр, матрас зэргээр толгойгоо хамгаал. Эсвэл шалан дээр доош харан хэвтэж, гараагаа толгой, хүзүүгээ халхал;
2. Гэрээ орхиж, гадагш гарахаар бол дээрээс унаж болзошгүй зүйлсээс болгоомжил;
3. Гадагш гарах гол хаалгаа байшин нурж, гарцгүй болохоос өмнө онгойлгох;

4. Хэрэв та 2-р давхарт байгаа бол доош буух гэж оролдох хэрэггүй. 2-р давхар арай аюул багатай байдаг.
5. Гүйхэд тохирсон хөлд эвтэйхэн, спорт загварын гутал өмсөх;
6. Зуух, хийн зуух, халаагуур зэрэг бүх төрлийн цахилгаан хэрэгслийг унтраах;
7. Ахмад настан болон өвчтэй хүмүүс, бага насны хүүхдүүдийг сайтар харгалзах;

**Хэрвээ таныг АЖИЛ ДЭЭРЭЭ (оффист) БАЙХ ҮЕД газар хөдлөвөл:**



1. Ойролцоох ширээн дор орж толгойгоо зөөлөн эд зүйлээр хамгаалах;
2. Номын шүүгээ зэрэг тавилгууд хөдөлж, унаж болзошгүйг анхаар. Тавилга багатай коридор болон үүдний хүлээлгийн хэсэг хамгийн аюул багатай байдаг.
3. Хөлд чинь тээглэх болон дээрээс унаж мэдэх зүйлсийн аль аль нь гадагш гарахад саад болохыг анхаараарай.

**Хэрвээ ТЕАТР/ҮЗВЭРИЙН ГАЗАРТ газар хөдлөвөл:**



1. Эгнээнүүдийн хооронд доош сууж, барьж яваа цүнхээрээ толгойгоо хархал.
2. Гарах зааварчилгаа өгөгдөөгүй бол үүд рүү яарах хэрэггүй.

**Хэрвээ ДЭЛГҮҮРТ газар хөдлөвөл:**



1. Цүнхээрээ толгойгоо халхал;
2. Бат бөх ширээн доогуур орох, эсвэл багана, хананы ойролцоо суух;
3. Гадагш гарах гарц руу яарах хэрэггүй. Дэлгүүрийн ажилтнуудын зааварчилгааг анхаарах, гадагш гарах бол шатаар буух;
4. Цахилгаан шат гэнэт зогсвол яаралтай тусламжийн товчийг дарж, тусламж дуудах;

**Хэрвээ ГАЗАР ДООРХ ХУДАЛДААНЫ ТӨВД газар хөдлөвөл:**



1. Ойролцоох хана, эсвэл томхон баганын ойролцоо очиж зааварчилгаа хүлээх;
2. Хэрэв гал гарвал, хамар амаа алчуураар таглаж, дөрвөн хөллөөд, хамгийн ойролцоох гарц дагуух ханыг дагаж мөлхөх;

Хэрвээ ГАЛТ ТЭРГЭНД газар хөдлөвөл:



1. Галт тэрэг огцом зогсож болзошгүй тул бариулаас сайтар барих;
2. Галт тэрэг зогсмогц цонхоор гарахыг оролдох буюу ослын үед хэрэглэдэг хаалгыг онгойлгох гэж яарах хэрэггүй. Зааварчилгаа өгөхийг хүлээж, тайван байх хэрэгтэй.

Хэрвээ ГАДАА ЯВЖ БАЙХАД газар хөдлөвөл:



1. Цүнхээрээ толгойгоо халхалж, машины ил зогсоол юмуу задгай газар луу гүйх. Шил, замын тэмдэг, шавар шохой гэх мэт зүйлсээс гэмтэхээс болгоомжлох;
2. Аюулгүй газар олж хоргодохыг хичээх. Хэдийгээр унаж ирэхээр аюултай зүйлс харагдахгүй байсан ч модон хийц бүхий барилга байгууламж, лаазалсан ундаа болон кофены автомат түгээгүүр, тоосгон хананы ойролцоо зогсож болохгүй. Хэзээ ч байшингийн дотор орж хоргодож болохгүй.
3. Газарт унасан өндөр хүчдэлийн цахилгаан шугамнаас болгоомжил.

Хэрвээ ЖОЛОО БАРЬЖ БАЙХАД газар хөдлөвөл:



1. Хэрэв газар хөдлөлтийн чичиргээ мэдэрвэл хурдаа хасч, замын зүүн гар талд машинаа байрлуулаад хөдөлгүүрээ унтраа;
2. Чичиргээ намжтал машинаасаа гарах хэрэггүй. Радиоогоор мэдээлэл ав.
3. Машинаасаа гарахдаа түлхүүрээ салгах хэрэггүй, мөн хаалгаа цоожлох хэрэггүй.

Хэрвээ таныг УНТАЖ БАЙХАД газар хөдлөвөл:



- Толгойгоо дэрээрээ халхал. Чичирхийлэл зогссоны дараа гутлаа өмсөөд гадагш гарах. Цахилгаан шат ашиглаж болохгүй.
- ХЭВТ, НУУГД, ХҮЛЭЭ командыг биелүүл

## IV. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ДАРАА АВАХ АРГА ХЭМЖЭЭ

### 4.1 Газар хөдлөлтийн дараа учирсан хохирол, гэмтэл, бэртэл байгаа эсэхийг шалгах

- Гэр бүлийн гишүүд чичирхийлэл бүрэн зогссоны дараа гэрийнхээ гадаа аль болох хурдан гарах
- Эхлээд өөрийгөө бэртэж гэмтсэн эсэхийг шалгаад дараа нь бусдад тусламж үзүүлэх



- Гэрийн болон ажлын утсыг шалга. Гамшгийн улмаас телефон утасны шугам эвдэрсэн эсэхийг шалгаж үзээд хэрэв эвдрээгүй, ажиллаж байвал яаралтай тусламж, шуурхай аврах алба руу гэрийн болон гар утсаараа ярих хэрэгтэй.
- Тоос, шорооноос ам, хамар, нүдээ хамгаал;
- Хэрвээ хэн нэгэн цус алдаж байвал цэвэр материал ашиглан цус тогтоох арга хэмжээ ав;
- Ухаан алдсан, зүрх нь зогссон хүн байвал хиймэл амьсгал, иллэг хий;



- Хүнд гэмтэлтэй хүнийг хөдөлгөж, тээвэрлэж болохгүй;
- Бэртэж, гэмтсэн хүмүүст шаардлагатай ус, дулаан хөнжил, гудсаар тусла;

- Тэжээвэр амьтдаа харгалза. Бүх тэжээвэр амьтдыг өөрийн хяналтанд байлга;
- Гамшгийн улмаас амьтад гэрээ олохоо больж, хянахад бэрхшээлтэй болж, гэрээсээ ч зугатаж болно. Хүний биед хортой химийн бодис, бордоо, цөмийн хаягдал дээгүүр амьтад туучин явж, ам хамрандаа хүргэхээс болгоомжлох нь зүйтэй. Гамшиг болсны дараа зарим амьтад их ууртай, догшин, тогтворгүй болж өөрчлөгддөг учраас гадны хүн, амьтад хохирол учруулахаас болгоомжилж, тэдэнд анхаарал тавих хэрэгтэй.

### 4.2 Аюул үүсгэж болзошгүй нөхцлүүдийг шалгах

- Газар хөдлөлт болсны дараа дахин доргилт өгдөг тул сэрэмжтэй байх. Ихэнхдээ хэдэн минут, өдөр, долоо хоног, сарын дараа тохиолддог.
- Хувцаслалт – зузаан материалтай өмд, урт ханцуйтай цамц, түрийтэй гутал, ажлын бээлий өмсөж өөрийгөө гэмтэж бэртэхээс хамгаал;
- Гал түймэр – бага хэмжээний галыг унтраахыг хичээ;
- Хий алдагдах – хий алдагдаж байгаа эсэхийг илрүүлэхийн тулд орчин тойрноо сайтар ажиглах, хэрэв хий үнэртэх юмуу ямар нэгэн шинж тэмдэг илэрвэл яаралтай арга хэмжээ ав;
- Цахилгааны утасны гэмтэл – хэрвээ гэмтэл байвал засварлах, боломжгүй бол бүрмөсөн салга;
- Нурсан эд зүйл-хаалга онгойлгох үед эд зүйлс нурж, дээрээс унахаас сэргийл;
- Шингэн зүйл асгарах – газар хөдлөлтийн дараа гэр, сууцандаа нэвтрэхдээ аливаа аюултай бодис, шингэн алдагдсан байхаас болгоомжлох, ил гал гарахыг хатуу хориглох хэрэгтэй.

### 4.2 Хэрэв нурангин дор дарагдсан бол

- Тайван байж орчин тойрноо ажиглаад, гадна байгаа хүмүүст өөрийгөө мэдэгдэх арга хэмжээ ав;




- Гал гаргаж болохгүй, хашгир, шүгэл үлээ, эсвэл хатуу зүйлээр хана цохь;
- Тамир тэнхээгээ гамнах хэрэгтэй
- Гэмтэж бэртсэн эсэхээ шалгаад, боломжтой бол өөртөө анхны тусламж үзүүл

#### 4.2 Орон нутгийн удирдлагын зааварчилгааг дагах

- Орон нутгийн удирдлага болон мэргэжлийн байгууллагаас гаргасан шийдвэр, цаг үеийн мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах хэрэгтэй



- Тухайлбал, иргэдийг нүүлгэн шилжүүлэх шийдвэр гарсан бол түүнийг биелүүл;
- Гамшгийн талаарх сүүлийн үеийн мэдээлэл, зааварчилгааг авахын тулд зөөврийн буюу зайгаар ажилладаг зурагт, радио сонс; Энэ нь эрчим хүч хязгаарлагдсан үед мэдээлэл авах эх сурвалж болно.
- Хүн бүр гамшигт нэрвэгдэгсдэд сайн дураараа туслах үйл ажиллагаанд идэвхийлэн оролцох нь зүйтэй.



### Хавсралт

1. Газар хөдлөлтийн үеийн бэлэн байдлын картын загвар
2. Аймаг, нийслэлийн Онцгой Байдлын Газар, Хэлтсүүдийн хаяг, харилцах утасны дугаар



### Хавсралт 1.

Газар хөдлөлтийн үеийн бэлэн байдлын картын загвар

Өөрийн овог, нэр	Цусны бүлэг		Төрсөн огноо	
Гэрийн хаяг			Утасны дугаар	
Яаралтай үед холбоо барих хүн	Хаяг	Тантай ямар холбоотой болох		
		Утасны дугаар		
Гэр бүлийн гишүүдийн нэрс		Тантай ямар холбоотой болох		

Яаралтай үед хэрэглэгдэх утасны дугаарууд

Нэрс	Утасны дугаар

### Хавсралт 2.

Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, аврах, гал унтраах ангиудын хаяг байршил, утасны дугаар

	Байгууллагын нэр	Яаралтай үед холбогдох утасны дугаар	Хаяг, байршил
1.	Онцгой Байдлын Ерөнхий газар	265726	УБ хот, Сүхбаатар дүүрэг, Партизаны гудамж 6 /Баруун 4 зам, Наран их дэлгүүрийн хойно/
2.	Нийслэлийн Онцгой байдлын газар, жижүүр	2622-48, 2002, 101	УБ хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Хувьсгалчдын өргөн чөлөө 16
3.	Шуурхай удирдлагын төв	3257-26, 9200-2204	УБ хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Самбуугийн 18-р гудамж
4.	Аврах отряд	2481, 3435-85, 9890-9400	УБ хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, Дунд голын хойд эрэг
5.	Аврах тусгай анги, жижүүр	6329-19, 9200-2071	УБ хот, СХД, 4-р хороо, Мах Импекс компаний хойно
6.	Шуурхай бүлэг 105	105, 2662-75, 2635-42	УБ хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Хувьсгалчдын өргөн чөлөө 16
7.	Баянгол дүүргийн ОБХ, дуудлага хүлээн авагч	6320-49, 9889-7263, 3010-80	УБ хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Төв түүхий эдийн ажилчдын байр
8.	Гал унтраах 18-р анги	9889-7264	УБ хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Төв түүхий эдийн ажилчдын байр

9.	Багануур дүүргийн ОБХ, дуудлага хүлээн авагч	1211-01	УБ хот, Багануур дүүрэг, 3-р хороо, үйлдвэрчний хэсэг
10.	Гал унтраах 64-р анги	20301	УБ хот, Багануур дүүрэг, 3-р хороо, үйлдвэрчний хэсэг
11.	Багахангай дүүргийн ОБХ, дуудлага хүлээн авагч	02221-01, 02224-4941	Багахангай дүүрэг, 1-р хороо, ЗДТГ-ын 2-р давхар
12.	Гал унтраах 80-р анги	2221-01	Багахангай дүүрэг, 1-р хороо, ЗДТГ-аас хойш 300 м
13.	Баянзүрх дүүргийн ОБХ, дуудлага хүлээн авагч	4603-10, 9200-6007	УБ хот, БЗД, 13-р хороо, БЗД-ийн 1-р давхар
14.	Гал унтраах 63-р анги	4603-11	УБ хот, БЗД, 8-р хороо, авто вокзалын хажууд
15.	Налайх дүүргийн ОБХ, дуудлага хүлээн авагч	1231-01, 70231-01	Налайх дүүрэг, 2-р хороо, Дамдингийн гудамж
16.	Гал унтраах 28-р анги	123-101	УБ хот, СХД, 5-р хороо, ЗДТГ
17.	СХ дүүргийн ОБХ, дуудлага хүлээн авагч	4964-01, 6311-10	УБ хот, СХД, 4-р хороо, Мах Имлекс компаний урд
18.	Гал унтраах 26-р анги	6320-59	УБ хот, СХД, 1-р хороо, Олон улсын хүүхдийн "Найрамдал" төв
19.	Гал унтраах 11-р анги	4964-01	УБ хот, СХД, 20-р хороо, Баянхошууны хуучин эцэс
20.	Гал унтраах 29-р анги	9312-7990	УБ хот, СБД, 6-р хороо, ЗДТГ
21.	СБ дүүргийн ОБХ, дуудлага хүлээн авагч	9812-2034	УБ хот, СБД, Дамбадаржаагийн 15-р хороо
22.	Гал унтраах 34-р анги	3570-77	

23.	Хан-Уул дүүргийн ОБХ, дуудлага хүлээн авагч	3422-56, 3799-47, 4971-01	
24.	Гал унтраах 14-р анги	3422-56	УБ хот, ХУД, 3-р хороо, Үйлдвэрийн цагаан хаалганы баруун талд
25.	Гал унтраах 30-р анги	3799-47	
26.	Гал унтраах 65-р анги	4971-01	УБ хот, ХУД, 12-р хороо, "Бөхөг" ХХК-ий зүүн талд
27.	Чингэлтэй дүүргийн ОБХ, дуудлага хүлээн авагч	3108-02, 7011-0571	УБ хот, ЧД, 4-р хороо, Хүнсний 1-р дэлгүүрийн баруун талд
28.	Гал унтраах 10-р анги	101	
29.	Архангай аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01332)-101, 22265,	Архангай аймаг, Эрдэнэбулган сум
30.	Гал унтраах 51-р анги		
31.	Баян-Өлгий аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч	(01422)-101, (01422)-21866	Баян-Өлгий аймаг, Өлгий сумын 1-р баг
32.	Гал унтраах 31-р анги		
33.	Баянхонгор аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01442)-101, (01442)-22030, 22111	Баянхонгор сумын 1-р баг
34.	Гал унтраах 16-р анги		
35.	Булган аймгийн ОБГ, дуудлага хүлээн авагч оператор	(01342)-101, 22430,	Булган сумын 5-р баг, Ханддоржийн гудамж
36.	Гал унтраах 20-р анги		
37.	Гал унтраах 50-р анги	9934-8011	Хангал сумын Хялганат тосгон

38.	Говь-Алтай аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01482)-101, 24880,	Есөн булаг сум, Харзад баг
39.	Гал унтраах 59-р анги		
40.	Говь-Сүмбэр аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01542)-101, (01542)-23025, 9654-0105	Сүмбэр сум, 2-р баг
41.	Гал унтраах 37-р анги		
42.	Дархан-Уул аймгийн ОБГ, дуудлага хүлээн авагч оператор	(01372)-105, (01372)-33759 267906-245	Дархан сумын 8-р баг
43.	Гал унтраах 22-р анги		
44.	Гал унтраах 54-р анги	9307-3787	Дархан сумын 1-р баг
45.	Аврах гал унтраах 55-р анги		
46.	Дорноговь аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01522)-101, (01522)-22301	Сайншанд хотын 1-р баг
47.	Гал унтраах 33-р анги		
48.	Дорнод аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01582)-21453, 101,	Хэрлэн сумын 6-р баг, Шүр захын урд талд
49.	Гал унтраах 52-р анги		
50.	Дундговь аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01592)-101, (01592)-23030, 9659-0106	Сайнцагаан сумын 8-р баг
51.	Гал унтраах 25-р анги		
52.	Завхан аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01462)-22365, 101, (01462)-22365	Улиастай сум, Богдын гол баг, Арлын хэсэг
53.	Гал унтраах 43-р анги		
54.	Гал унтраах 39-р анги	9302-5754	Тосонцэнгэл сум

55.	Орхон аймгийн ОБГ, дуудлага хүлээн авагч оператор	(01352)-101, (01352)-20415, 200001,	Баянөндөр сум, Баянцагаан баг
56.	Гал унтраах 56-р анги		
57.	Гал унтраах 58-р анги	(01352)-71101	Баянөндөр сум, Эрдэнэт үйлдвэр
58.	Гал унтраах 81-р анги	(01352)-32101	Цагаанчулуут баг
59.	Өмнөговь аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01532)-101, 23482, 9653-0105	Даланзадгад сум, Нанзад 5-р баг, Цагдаагийн хэлтсийн зүүн талд
60.	Гал унтраах 21-р анги		
61.	Өвөрхангай аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01322)-101, (01322)-22740	Арвайхээр сумын 5-р баг, "Мэргэд" цогцолбор сургуулийн урд талд
62.	Гал унтраах 45-р анги	(013258)-101	Хархорин сум
63.	Сүхбаатар аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01512)-101, (50511)-101, (01512)-21030	Баруун-Урт сум, 5-р баг, Төв эмнэлгийн зүүн хойно
64.	Гал унтраах 15-р анги		
65.	Сэлэнгэ аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(02362)-101, (02362)-22255	Сүхбаатар сум, 4-р баг, 2-р хэсэг, Цагдаагийн хэлтсийн зүүн талд
66.	Гал унтраах 36-р анги	(02362)-23874	
67.	Төв аймгийн ОБГ, дуудлага хүлээн авагч оператор	(01272)-101, (01272)-23060	Зуунмод сумын 5-р баг, Төв эмнэлгийн урд талд
68.	Гал унтраах 24-р анги		
69.	Аврах салбар	(01272)-22834	Зуунмод сумын 2-р баг, Дивизийн байрны хажууд
70.	Увс аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01452)-101, (01452)-22602, 9645-0106	Улаангом сумын 10-р баг
71.	Гал унтраах 41-р анги		

72.	Ховд аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01432)-101, (01432)-23801,	Жаргалант сум, Нарангийн баг, зүүн 4 зам
73.	Гал унтраах 48-р анги		
74.	Аврах отряд	9643-0105	
75.	Хөвсгөл аймгийн ОБХ, дуудлага хүлээн авагч оператор	(01382)-101, (01382)-22750, 9865-2570	Мөрөн сумын 7-р баг, Нэгдсэн эмнэлгийн зүүн урд
76.	Гал унтраах 27-р анги		
77.	Хэнтий аймгийн ОБГ, дуудлага хүлээн авагч оператор	(01562)-101, (01562)-22111, 9301-2087	Өндөрхаан хот, Хэрлэн сум, 1-р баг, Тэмүүжиний гудамж
78.	Гал унтраах 32-р анги		
79.	Гал унтраах 49-р анги	9820-9949	Бор-Өндөр тосгоны 2-р хэсэг

## Ашигласан материал

1. Газар хөдлөлт – танин мэдэхүйн ном. ШУА-ийн Одон орон, Геофизикийн судалгааны төв, Газар хөдлөл судлах сектор, УБ хот, 2007 он
2. Гамшгаас өөрийгөө хамгаалах арга хэмжээний зааварчилгаа. Хэвлэл мэдээллийн ажилтан, иргэдэд зориулсан гарын авлага, МОН/08/305 төсөл, УБ хот, 2010 он
3. Газар хөдлөлтийн аюулаас өөрсдийгөө хамгаалъя. Ард иргэдэд зориулсан сурталчилгааны материал. Токио хотын захиргааны Гамшгаас урьдчилан сэргийлэх сектор, 2006 он
4. <http://en.wikipedia.org>
5. Гамшгийн менежмент. Тэргүүн дэвтэр. МОН/02/305 төсөл. УБ хот, 2003 он
6. Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга зүй. МОН/08/305 төсөл. УБ хот, 2010 он

